СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

2.1. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаасны нэр:	"Э-Транс Ложистикс" ХК
Хувьцааны төрөл:	Энгийн
Үнэт цаасны хэлбэр:	Биет бус
Үнэт цаасны нэрлэсэн үнэ:	100
Үнэт цаасны нийт тоо ширхэг:	46,200,000
Хөрвөх үнэт цаасны тоо ширхэг:	38,500,000
Нийтэд санал болгох хувь:	16,67%
Нийтэд санал болгох үнэт цаасны тоо ширхэг:	7,700,000
Анхдагч зах зээлд байршуулах:	Нийт хувьцааны 16,6% буюу 7,700,000 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар анхдагч зах зээлд олон нийтэд байршуулна.
Санал болгох үнэ:	Үнэт цаасыг олон нийтэд санал болгох доод үнэ 120 төгрөг байна.

2.2. НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ШИЙДВЭР

Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 43, 63-р зүйл, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн Үнэт цаас гаргагчийн 2011/03/31-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын 01, 02 тоот тогтоолын дагуу хувьцаагаа олон нийтэд санал болгон дүрмийн сангаа нэмэгдүүлж, компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

2011/03/31-ны өдрийн 03 тоот тогтоолоор компанийн хувьцаа эзэмшигчид нь тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй бөгөөд шинээр гаргаж буй 7,700,000 ширхэг хувьцааг 100% олон нийтэд санал болгоно.

5309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

УЛААНБААТАР ХОТ